



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 5 сарын 23 өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргаж буй
үнэт цаасыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх журам”-ын 3.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”-ийн Монгол Улсад гаргах нэг бүр нь 640 /зургаан зуун дөч/ төгрөгийн үнэ бүхий нийт 4,000,000 /дөрвөн сая/ ширхэг энгийн хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”-ийн нэг бүр нь 640 /зургаан зуун дөч/ төгрөгийн үнэ бүхий нийт 101,100 /нэг зуун нэг мянга нэг зуу/ ширхэг хувьцааг иргэний бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөр тасалбар болгон Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэжинст сумын нийт 5,055 иргэн тус бүрт 20 ширхэг хувьцааг нэр заан эзэмшүүлэн бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын 1-д заасан хувьцаанаас 3,898,900 /гурван сая найман зуун ерэн найман мянга есөн зуу/ ширхэг хувьцааг тогтоосон үнийн аргаар тус бүрийг 640 /зургаан зуун дөч/ төгрөгөөр нийтэд санал болгон худалдахыг “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” /Петер С.Акерли/, худалдагдаагүй үлдсэн хэсгийг худалдан авахыг “БиДиСек ҮЦК” ХК /Д.Даянбилгүүн/-д тус тус мэдэгдсүгэй.

4. Хорооноос анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцох хүртэлх хугацаанд үнэт цаасны арилжаанаас татан төвлөрүүлэх хөрөнгийг тусгаарлахыг “Арилжааны төлбөр тооцоо” ХХК /О.Эрдэнэгэрэл/-д үүрэг болгосугай.

5. Үнэт цаасны танилцуулга холбогдох баримт бичгийг бэлтгэхэд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, зөрүүтэй, алдаатай мэдээлэл тусгасны улмаас хөрөнгө оруулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг

“БиДиСек ҮЦК” ХК /Д.Даянбилгүүн/, “Өмгөөллийн И Эл Си” ХХН /Б.Баяр/-д тус тус анхааруулсугай.


6. Тогтоол батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /Х.Алтай/-д үүрэг болгосугай:

1/ Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаасаа бүртгүүлсэнтэй холбоотойгоор мэдээллийн ил тод байдал, арилжааны хяналттай холбоотой асуудлаар хуулийн этгээдийн анхдагч бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр идэвх санаачилга гарган ажиллах;

2/ Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалж ажиллах.

7. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН